



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 358

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3, 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Сургуулийн албан ажлын хэрэгцээнд зориулан 1 ширхэг суудлын автомашиныг 150,000,000.00 (нэг зуун тавин сая) төгрөгт багтаан өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр олж авахыг зөвшөөрч, худалдан авах шинэ автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар тогтоосугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ням-Очир, Монгол Улсын Их Сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Я.Төмөрбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

000215

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 07 дугаар сарын 20 ны өдрийн  
...352... дугаар тогтоолын хавсралт



Монгол Улсын Их Сургуулийн худалдан авах автомашины техникийн үзүүлэлт,  
үнийн дээд хязгаар

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Худалдан авах үнийн дээд хязгаар
				(төгрөг)
1	Суудлын тоо 8, хөдөлгүүрийн багтаамж 2500-3000 cc	ш	1	150 000 000,00
Нийт дүн			1	150 000 000,00
				(нэг зуун тавин сая)